



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.04.19 № 151

танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

“Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, ашиглалтад тавих хяналтад онцгой анхаарч, төлөвлөсөн үр дүнг тооцох шаардлагатай байна.

Аудитын код: ОРА-2024/18-13-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn
Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn
Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товьёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	6
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүй байна.	7
1.1. ТАХ-ний 88.2 хувь нь төлөвлөлтийн шаардлагад нийцсэн байна.....	7
1.2. ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгахгүй байгаа нь эрсдэл үүсгэж байна.	7
1.3. ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгожээ.....	9
БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хяналтыг сайжруулан, хариуцлага тооцох хэрэгтэй байна.....	10
2.1. Төлөвлөсөн хугацааг сунгасан 2 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалсан бөгөөд ажил зогссон байна.	10
2.2. ТАХ-нд хэрэгжүүлэх хяналтыг сайжруулж, хариуцлага тооцох хэрэгтэй байна.	11
2.3. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.	13
БҮЛЭГ 3. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг тооцох боломжгүй, бүрэн хүчин чадлаар ашиглаж чадахгүй байна.....	14
3.1. Хэрэгжсэн ТАХ-ний 50 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.	14
3.2 Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг бодитой хэмжих нөхцөл бүрдээгүй байна.	14
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	15
ЗӨВЛӨМЖ:.....	15
Холбогдох байгууллагын санал:	16

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЗГХЭГД	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орхон аймагт хэрэгжих ТАХ	6
Хүснэгт 2	Бүрэн дуусаж, ашиглалтад хүлээн авсан ТАХ	6
Хүснэгт 3	Санхүүжилт	10
Хүснэгт 4	ТАХ-ний хэрэгжилт	10

<p>Аудит үндэслэл, эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв"-ийн дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, • Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ зэрэг холбогдох байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитын явцад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аудитыг чиглүүлж</p>

гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр,
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”,

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох, Ц.Одгэрэл нар 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

**Аудит хийхэд
учирсан хүндрэл
бэрхшээл**

Үүсээгүй болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан ба хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 1129, шинээр эхлэх 10, нийт 1139 ТАХ-г баталсан.

Үүнээс Орхон аймагт өмнөх оноос шилжин хэрэгжих 57,534.4 сая төгрөгийн 17 ТАХ-г 20,407.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан ба 14 ТАХ-г хэрэгжүүлж дуусахаар төлөвлөжээ.

Хүснэгт 1		Орхон аймагт хэрэгжих ТАХ				
ТЕЗ буюу сайд	ТАХ-ний тоо	Эрх шилжсэн		ТАХ-ний тоо	Эрх шилжээгүй	
		Төсөвт өртөг /сая төгрөг/	Санхүүжих дүн сая төгрөг		Төсөвт өртөг /сая төгрөг/	Санхүүжих дүн сая төгрөг
БХБС				2	4,934.7	2,945.5
ХХААХҮС				2	3,470.0	2,470.0
БШУС	1	6,634.4	1,420.4	4	22,391.1	7,292.4
ЗТХС	2	4,104.7	286.1	2	7,993.7	4,143.3
ЗГХЭГД				2	5,328.3	1,232.3
ХНХС				2	2,677.5	617.6
Нийт	3	10,739.1	1,706.5	14	46,795.3	18,701.1

Аймгийн Засаг даргад эрх шилжсэн 14, эрх шилжээгүй 3 ТАХ байгаагаас 10 нь бүрэн дуусаж, 4 нь 2024 онд үргэлжлэн хэрэгжиж, 3 нь гүйцэтгэгчээс шалтгаалан дуусаагүй байна.

Хүснэгт 2		Бүрэн дуусаж, ашиглалтад хүлээн авсан ТАХ	
Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Хүлээн авсан актын дугаар	
IX.1.17	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/	14/2023	
IX.2.4	Явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг баг/	16/2022	
III.1.4	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/	36/2023	
III.1.11	Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/	20/2022	
VIII.2.1.7	Ахмадын өргөөний барилга /Орхон, Жаргалант сум/	32/2023	
IX.1.66	Инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Орхон, Баян-Өндөр сум/	17/2023 24/2023	
X.3.4.1	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/	23/02	
XII.1.1.20	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.6 км /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж, Эрдэнэ баг/	21/02/173	
XIII.3.3	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	ОРАОНӨГ /202312145	
XIII.3.6	Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум/	23/03 23/06	

Эрх шилжсэн ТАХ-ний гүйцэтгэлийг холбогдох байгууллага хянасны дагуу 15,296.55 сая төгрөгөөр санхүүжүүлж, 598.55 сая төгрөгийг орон нутгийн барьцааны дансанд төвлөрүүлсэн байна.

Эрх шилжээгүй 3 ТАХ-ний санхүүжилт холбогдох ТЕЗ-д хамаарна.

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүй байна.

1.1. ТАХ-ний 88.2 хувь нь төлөвлөлтийн шаардлагад нийцсэн байна.

Орхон аймагт Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар өмнөх оноос шилжин хэрэгжих барилга байгууламж 14, ТЭЗҮ 1, тоног төхөөрөмж 2, нийт 17 ТАХ баталснаас 9 ТАХ-ний төсөвт өртгийг нэмэгдүүлсэн ба 15 нь төлөвлөлтийн шаардлага хангасан байна.

Төсөв нэмэгдүүлсэн 9 ТАХ нь 2013-2020 онд эхэлсэн болон ашиглалтад хүлээн авсан ТАХ бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлтөд магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна.

Аймгийн Засаг даргад ХХААХҮС-ын багцаас “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл”-ийг эрх шилжүүлэхдээ тоног төхөөрөмж ангилалд төлөвлөлт, зорилт болон хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох баримт бичгээр баталгаажаагүй ТАХ-г батлуулж, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх, тайлагнах эрхийг шилжүүлжээ. Бараа, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, төслийн хэрэгцээ шаардлага, хүрэх үр дүн тодорхойгүй, төлөвлөлтийн шаардлага хангуулаагүйгээс худалдан авах ажиллагаа 2 сараар хойшлоход хүрсэн байна.

Мөн БШУС-ын багцаас эрх шилжсэн “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/” боловсруулах ТАХ нь төлөвлөлт, зорилт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх болон холбогдох баримт бичгээр баталгаажаагүй бөгөөд техникийн даалгаварт барилга байгууламж, тоног төхөөрөмжийг тусгасныг Сангийн яам хянаж санхүүжүүлэх боломжгүй болсон тул ТЭЗҮ боловсруулах, барилга байгууламж, тоног төхөөрөмж нийлүүлэх гэж гэрээнд өөрчлөлт оруулсан байна.


Шинээр хэрэгжүүлж байгаа ТАХ-ний үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоог бүрэн тооцоолоогүй, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг огт гаргаагүй, хийсвэр мэдээлэл тусгадаг байна.

Иймд холбогдох ТЕЗ нарт хүргүүлэх зөрчлийн нэгтгэлд оруулан, хүргүүлэхээр ҮАГ-т санал уламжлав.

1.2. ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгахгүй байгаа нь эрсдэл үүсгэж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өмнөх онуудаас үргэлжлэн хэрэгжиж буй 3 ТАХ-г огт тусгаагүй ба 2023 онд хэрэгжиж дуусгахаар баталсан 2 ТАХ-ний өртөг, санхүүжүүлэх дүнг бүрэн тусгаагүй байна. Тухайлбал:

- Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/ 2013 онд эхэлсэн, 798.0 сая төгрөгийн өртөгтэй, эрх шилжээгүй тул санхүүжилтийн мэдээлэл БШУЯ-нд байгаа болно.



- Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/ 2019 онд эхэлсэн, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулж, 2019 онд эхэлсэн, 1,000.0 сая төгрөгийн өртөгтэй, 806.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 81%-ийн гүйцэтгэлтэй, бүрэн хэрэгжээгүйгээс цонх хагарч, дээврийн ажлыг дахин гүйцэтгэх нөхцөл үүссэн.




- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/ 2019 онд гэрээ байгуулж, эхэлсэн бөгөөд магадлалаар баталгаажсан нийт төсөвт өртөг 3,957.1 сая төгрөг бөгөөд 2,500.0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж, 1,950.0 сая төгрөгийн санхүүжилт авсан, 55 хувийн гүйцэтгэлтэй. 2022, 2023 онд төсөв батлаагүй. Хадгалалт, хамгаалалтгүйгээс хийсэн цонх хагарч дахин ашиглах боломжгүй болсон, бетон шал хагарсан байна.



- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/ 2020 онд эхэлсэн ба магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 3,943.6 сая төгрөг. Магадлалаар хянасан төсвөөс батлагдсан төсвийн дүнгээр салгаж гэрээ байгуулсан, гэрээний үнийн дүнгээрх гүйцэтгэл 100 хувь, барилгын ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна. 2023 онд 589.6 сая төгрөгөөр төсөв нэмсэн.



- Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/ магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 10,557.7 сая төгрөг байтал 6,634.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр баталсан байна. 2013 онд эхэлсэн ба 65.3%-ийн гүйцэтгэлтэй, 2024 онд шилжин хэрэгжинэ.



Эрх шилжин хэрэгжиж буй 2 ТАХ-г гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлан, холбогдох арга хэмжээ хэрэгжүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

ТАХ-г зураг төсөлгүй, төсөвт өртгийг хэрэгжих хугацаатай уялдуулаагүй төлөвлөснөөр ТАХ бүрэн хэрэгжихгүй байх, удаашрах, удааширснаар хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдах, төсөвт өртөг анх төлөвлөснөөс нэмэгдэх, гүйцэтгэгчид өртөг нэмэгдүүлэх хандлага үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

1.3. ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгожээ.

Эрх шилжсэн ТАХ-ний гүйцэтгэлийг холбогдох байгууллага хянаж, баталгаажуулсныг Сангийн яам хянаж, 15,891.1 сая төгрөгөөр эрх нээснийг 15,296.55 сая төгрөгөөр санхүүжүүлж, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 456 дугаар тогтоолын дагуу 2 ТАХ-ний 598.55 сая төгрөгийг орон нутгийн барьцааны дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3 ТЭЗ буюу сайд	Санхүүжилт		Хяналтын зардалд	Баталгаа 5%	сая.төгрөг
	Эрх нээсэн дүн	Гүйцэтгэгчид олгосон			Барьцааны дансанд төвлөрүүлсэн
БХБС	144.40	124.55	-	19.85	-
ХХААХҮС	2,470.00	2,470.00	-	-	-
БШУС	7,287.53	7,049.46	150.69	87.38	-
ЗТХС	4,143.34	3,555.66	90.01	-	497.67
ЗГХЭГД	1,232.25	1,232.25	-	-	-
ХНХС	617.58	457.81	12.12	46.77	100.88
Нийт	15,895.10	14,889.73	252.82	154.00	598.55

Төсөвт өртгийн бүрдэлд багтсан норм, нормативын санд төвлөрүүлэх зардлыг санхүүжилтээс суутгахгүй олгодог бөгөөд гүйцэтгэгч холбогдох норм, нормативын санд төлж, төлбөрийн баримтыг гүйцэтгэлийн баримтад хавсаргадаг байна.

Захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардлыг тухайн дансанд төвлөрүүлж, зохиогчийн хяналтын зардлыг гэрээ байгуулан, хянаж, акт үйлдэж баталгаажуулан, олгож байна. Захиалагчийн хяналтын зардлыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хянан, олгож байна.

Иргэдийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,470.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалыг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “Төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэж заасантай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хяналтыг сайжруулан, хариуцлага тооцох хэрэгтэй байна.

2.1. Төлөвлөсөн хугацааг сунгасан 2 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалсан бөгөөд ажил зогссон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-г холбогдох зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн хэдий ч 8 ТАХ-ний гэрээний хугацааг сунгаж, 10 ТАХ-нд нэмэлт гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 4 ТАХ-ний ангилал	ТАХ-ний хэрэгжилт		
	Нийт ТАХ тоо	Бүрэн хэрэгжсэн	Гүйцэтгэлийн хувь
Барилга байгууламж	14	7	50%
Тоног төхөөрөмж	2	2	100%
ТЭЗҮ	1	1	100%
Нийт	17	10	83.3%

ТАХ-ний хэрэгжилтийг авч үзвэл нийт барилга байгууламжийн 50 хувь, тоног төхөөрөмж, ТЭЗҮ бүрэн хэрэгжсэн байна.

Хэрэгжилт дутуу 7 ТАХ-ний 4 нь он дамжин хэрэгжих буюу гэрээний хугацаа болоогүй, 3 нь бүрэн хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй 3 ТАХ-ний хувьд худалдан авах ажиллагаа хүчингүй болсон, санхүүжилт батлагдаагүй, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан байна. Тухайлбал:

- Инженерийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/ ТАХ-ний зураг, төсөвт магадлалаар хянаж баталгаажуулах боломжгүй бөгөөд энэ нь Баянцагаан багийн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлаагүйгээс шалтгаалсан байна. Гүйцэтгэгчээс шалтгаалсан тул гэрээг цуцалж, 2023 онд 2,801.1 сая төгрөгийн тендер зарлаж, гүйцэтгэгч шалгаруулсан хэдий ч Сангийн яаманд гомдол гаргаж, тендерийг цуцалсан байна.

- Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан ажил удааширсан Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/ гүйцэтгэгч Ээлт-Өлгий ХХК-ийн 1,749.1 сая төгрөгийн ажил 2023 онд хэрэгжиж дуусаагүй байна.

- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Говил баг/ гүйцэтгэгч 2023 онд 589.6 сая төгрөгөөр барилгын материалын үнийн зөрүүг авсан бөгөөд барилгын ажил гүйцэтгээгүй байна.

ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын тогтоолоор ТАХ-ний санхүүжүүлээгүй үлдэгдлийг байршуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасантай нийцэхгүй байтал жил бүр тухайн шийдвэрийг гаргасаар л байна.

Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан ажил удааширсан Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/ 1,749.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй ТАХ гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, ажлыг дуусгаж хүлээн авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.


2.2. ТАХ-нд хэрэгжүүлэх хяналтыг сайжруулж, хариуцлага тооцох хэрэгтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн эрх шилжсэн 14 ТАХ-нд ХББЗА ОНӨААТҮГ, эрх шилжээгүй 3 ТАХ-нд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар захиалагчийн тавих үе шатны явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуу барилгын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг, холбогдох баримтаар баталгаажуулжээ.

Зарим ТАХ-ний гүйцэтгэлд хийсэн хяналт сул байгаагаас ТАХ-ний үр дүн хангалтгүй байна. Тухайлбал:

1. Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/-ыг гүйцэтгэгч Ээлт-Өлгий ХХК хийсэн барилгын өрлөг тэгш бус хийгдэж, гадна фасадын хөөс буулгаж дахин хийх шаардлага үүссэн, үр дүнгүй хөрөнгө оруулалт болж, хөрөнгө түгжсэн байна.



2. Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/ гүйцэтгэгч Уран хангай групп ХХК-ийн хийсэн барилгын суурийн ханын хажуугийн хамгаалалт, дулаалга хийгдээгүй, хөрсний ус орсон байна. Багана хэв хашмалын уулзварт даавуу, бээлий хийсэн, ил гарсан арматурууд зэвэрсэн, диапрагмын өндөр стандартаас намхан хийгдсэн байна. Гүйцэтгэгч хүлээн зөвшөөрч гэрээ байгуулсан хэдий ч төсөвт өртөг нэмүүлэх, төсөв хүрэлцээгүй гэж тайлбарлаж буй нь уг ТАХ-г удааширч, хугацаандаа дуусахгүй байх эрсдэл үүсэхээр байна.



3. Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/ гүйцэтгэгч Шинжүү ХХК-ийн хийсэн дотор замаск, өнгөлгөө муу хийсэн байна.



4. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/ гүйцэтгэгч Воком констракшн ХХК-ийн боловсруулсан ТЭЗҮ-г хүлээн авахдаа барилгын зураг төсөв 65.2 сая төгрөгөөр тусгаж санхүүжилт авсан хэдий ч зураг төсөв гүйцэтгэгчтэй 25.0 сая төгрөгийн гэрээ байгуулсныг тулгаж шалгаагүй, хийгдсэн судалгааг үнэлж дүгнээгүйгээс суурь судалгаа, зардлын задаргаа анхан шатны баримт нотолгоогүйгээр хүлээн авсан, газар олголт хийгээгүй,

аймгийн ерөнхий төлөвлөгөөнд тусгаагүй, ТЭЗҮ-ийн өртгийг сайн тооцоолоогүй, үрэлгэн төсөв баталж, хэрэгжүүлсэн байна.

Зураг төсөв гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнээс илүү олгосон зураг төсвийн үнэ 40.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

ТАХ-ний гүйцэтгэлд гарч буй зөрчлүүд нь захиалагч болон зохиогчийн хяналт үр дүн муутайгаас шалтгаалж байна. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасан ч улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж, эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллаагүйтэй холбоотой байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын хяналтыг сайжруулж, тулган баталгаажуулахад зөрчил үүсгэсэн гүйцэтгэгчийн гэрээний үүргийг хангуулах зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв.

Эрх шилжин хэрэгжсэн 8 ТАХ дуусаж, улсын комиссын ажиллан, ашиглалтад хүлээн авсан байна.

2.3. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Эрх шилжин хэрэгжиж дууссан 6 ТАХ-г барилга байгууламжийн, бүрэн хэрэгжиж дуусаагүй 6 ТАХ-г дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэсэн байна.

Харин Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлтөд магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажиж, нэмэлт гэрээгээр олгосон 5 ТАХ-ний 2,103.5 сая төгрөгийг хөрөнгөд бүртгээгүй байна. Энэ нь тухайн төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяаны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгийг нэгтгэн, өмчлөлийн асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар шийдвэрлүүлж бүртгэх болсонтой холбоотой байна.

Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" болон олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төслөөр худалдан авсан 126 нэр төрлийн 2,470.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нь улсын болон орон нутгийн төсөвт байгууллагын бараа материалд бүртгэлтэй, иргэдэд гэрээгээр ашиглуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24; 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг" гэж заасантай нийцэхгүй байна.

Тухайн байгууллагуудын хөрөнгөд бүртгэлтэй хэдий ч зориулалт бусаар ашиглах, худалдан борлуулах, зорилтот хэрэглэгчийг үнэн зөв тодорхойлоогүйгээс төслийн үр дүнг бууруулах эрсдэл үүсгэж байна.

БҮЛЭГ 3. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг тооцох боломжгүй, бүрэн хүчин чадлаар ашиглаж чадахгүй байна.

3.1. Хэрэгжсэн ТАХ-ний 50 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

Бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-ээс зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар 4 ТАХ-г ашиглаж байна. Харин инженерийн шугам сүлжээг бүрэн хүчин чадлаар ашиглах нөхцөл бүрэн бүрдээгүй, ТЭЗҮ-г хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй зэрэг нь төсвийн үр нөлөөг бууруулж байна.

"Шинэ хөдөө" болон "Үйлдвэрлэгч баг" төслөөр худалдан авсан 126 нэр төрлийн 9,979 ширхэг 2,470.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 412 иргэн, аж ахуйн нэгжид гэрээгээр ашиглуулж байгааг аудитын явцад тулган баталгаажуулах боломжгүй бөгөөд хөрөнгө бүртгэсэн байгууллага гэрээгүйгээр 150.5 сая төгрөгийн 6,611 ширхэг барааг иргэдэд олгосон байна.

3.2 Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг бодитой хэмжих нөхцөл бүрдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-д "эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ" гэж заасан ч хэрэгжүүлж байгаа ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу үнэн зөв, бодитой тооцоолоогүй нь ТАХ-үүд үр дүнтэй болсон эсэхийг тогтоох боломжгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөгөөр 2023 онд Орхон аймагт 2 багийн цогцолбор барилга ашиглалтад орж, баг, өрхийн эрүүл мэндийн төв, Хууль зүйн туслалцааны төв зэрэг байгууллагын үйл ажиллагааг нэг дороос авах боломж бүрджээ. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгч 412 иргэн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх гарааны тоног төхөөрөмж, бараа материалаар хангагдсан байна.

Мөн шинээр барьж байгуулсан инженерийн шугам сүлжээнээс 3,096 метр дулаан, хэрэгцээний халуун, хүйтэн усны шугамыг бүрэн ашиглаж байгаа ба 550 метр шугам болон шинээр барьсан ус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж бүрэн суурилуулаагүйгээс ашиглаагүй байгаа нь хөрөнгийн үр нөлөөг бууруулж байна.

Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалт, түүний үр өгөөж тооцох үнэлгээ хийх удирдамжийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухай бүр төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэхээр заасан хэдий ч 2023 онд аймгийн Засаг даргад ирүүлээгүй байна.

Аудитаар илэрсэн 6,932.6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 6,932.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын ТАХ-ний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүй нь эрсдэл үүсгэж байна.
- ТАХ-ний 88.2 хувь нь төлөвлөлтийн шаардлагад нийцсэн байна.
- ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгахгүй байгаа нь эрсдэл үүсгэж байна.
- ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгожээ.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хяналтыг сайжруулан, хариуцлага тооцох хэрэгтэй байна.
- ТАХ-үүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, гэрээ сунгасан байна.
- ТАХ-нд хэрэгжүүлэх хяналтыг сайжруулж, хариуцлага тооцож байх хэрэгтэй байна.
- Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг тооцох боломжгүй, бүрэн хүчин чадлаар ашиглаж чадахгүй байна.
- Хэрэгжсэн ТАХ-ний 50 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
- Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг бодитой хэмжих нөхцөл бүрдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Эрх шилжин хэрэгжих холбогдох сайдын багцын төсөвлөлтийн шаардлага хангаагүй, урсгал зардлын шинжтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулж, санхүүжүүлэхгүй байх.
- Хугацаандаа дуусаагүй, хэрэгжилт удааширсан ТАХ-нд анхаарч, хадгалалт, хамгаалалтын байдлыг хариуцан ажиллах.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангуулж, төлөвлөсөн үр дүн тооцож, зориулалтын дагуу ашиглан үр нөлөөг сайжруулах.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг БШУС, ХХААХҮС нарын зөрчлийн нэгтгэлд тусгуулах саналыг уламжилж байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргад ХХААХҮС-ын багцаас “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл”-ийг эрх шилжүүлэхдээ төлөвлөлт, зорилт болон хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох баримт бичгээр баталгаажуулах ТАХ-г батлуулж, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх, тайлагнах эрхийг шилжүүлжээ. Бараа, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, төслийн хэрэгцээ шаардлага, хүрэх үр дүн тодорхойгүй, төлөвлөлтийн шаардлага хангуулаагүйгээс худалдан авах ажиллагаа 2 сараар хойшлоход хүрсэн байна.
2. Мөн БШУС-ын багцаас эрх шилжсэн “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/” боловсруулах ТАХ нь төлөвлөлт, зорилт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх болон холбогдох баримт бичгээр баталгаажуулах бөгөөд техникийн даалгаварт барилга байгууламж, тоног төхөөрөмжийг тусгасныг Сангийн яам хянаж санхүүжүүлэх боломжгүй болсон тул ТЭЗҮ боловсруулах, барилга байгууламж, тоног төхөөрөмж нийлүүлэх гэж гэрээнд өөрчлөлт оруулсан байна.

Холбогдох байгууллагын санал: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын мэргэжилтнүүдтэй хамтран хэлэлцэж, шийдвэр гаргах нөхцөл байдлыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР *В. Жавзмаа* В.ЖАВЗМАА
АУДИТОР *Б. Бямбаатогтох* Б.БЯМБАТОГТОХ
АУДИТОР *Ц. Одгэрэл* Ц.ОДГЭРЭЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *Б. Буян-ундрах* Б.БУЯН-УНДРАХ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц. Нармандах* Ц.НАРМАНДАХ

